

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС  
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН 2017 ОНЫ 12 САРЫН 12-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2018.01.03

**Үүрэг даалгавар:2** Шинэ жилийн баярын өдрүүдэд хог хаягдлын цэвэрлэгээ, тээвэрлэлтийг хуваарийн дагуу зохион байгуулж ажил үйлчилгээг хэвийн үргэлжлүүлэх. /ШУЗТөвтэй уялдан мэдээллээ өгч, тайлагнаж ажиллах/



**Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Ахмадын хотхоны 901, 902, түр оршин суух 813 дугаар байрны хогийн цэг дэх хог хаягдлыг ачуулах арга хэмжээг Сүхбаатар дэвшил ХХК-тай хийгдсэн гэрээний дагуу 2017 оны 12 дугаар сарын 27, 31-ны өдөр нийт 40 тн хогийг ачуулах арга хэмжээг зохион байгуулсан.



**Үр дүн:** Хотхоны хог хаягдлын цэгт баяр амралтын өдрүүдэд хур хог хаягдал үүсгэлгүй оршин суугчдын ая тухтай орчинг бүрдүүлж ажилласан.

**Үүрэг даалгавар:3** Шинэ жилийн баяраар 4 өдөр амрахтай холбогдуулан гол гудамж талбай хүн ихээр төвлөрдөг, зорчдог, үзвэр худалдаа үйлчилгээний газар, автобусны буудлууд, авто зам болон сүүдэр хэсгийн газрын жагсаалт судалгааг гаргаж цас мөсний цэвэрлэгээ, халтиргаа гулгааг арилгах цэвэрлэх ажлыг зохион байгуулж, мэдээг 12 сарын 27-ны өдөр ТХХУХ-т ирүүлэх./



**Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Тус хотхоны 901,902 дугаар байр, түр оршин суух 813 дугаар байрны гадна талбай дахь нийтийн эзэмшлийн 850м<sup>2</sup> зам талбайн цас, мөсийг цэвэрлэх ажлыг 2017

оны 12 сарын 26 –ны өдөр зохион байгуулж нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр явган хүний болон авто зам дагуух мөстсөн зам талбайг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

**Үр дүн:** Оршин суугч иргэдийн зорчих хэсгийн халтиргаа гулгааг арилгах зам гарцаар эрсдэлгүй зорчих нөхцлийг хангуулж дүнг нийслэлийн Захирагчийн ажлын

албаны тохижилт хог хаягдлын удирдлагын хэлтэст 2017 оны 12 сарын 27-ны өдрийн 108 дугаар албан тоотоор цахимаар хүргүүлсэн.

**Үүрэг даалгавар:6** Шинэ жилийн баярын өдрүүдэд болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлж, хариуцлагатай жижүүр томилж ажиллуулах. /ШУЗТөвтэй уялдан мэдээллээ өгч, тайлагнаж ажиллах/

Тус хотхоны даргын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн “Хариуцлагатай эргүүл жижүүр томилох тухай” А/ 28 дугаар тушаал гарган 2017 оны 12 сарын 29-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд хариуцлагатай жижүүрүүдийг томилгоожуулж ажилласан.

**Үр дүн:** Хотхон ашиглалт үйлчилгээр хариуцаж буй 901,902 дугаар байр, түр оршин суух 813 дугаар байрны оршин суугч иргэдээс баяр амралтын өдрүүдэд нийт 23 дуудлага ирүүлсэнээс цахилгаан шаттай холбоотой 11, цахилгаан ашиглалттай холбоотой 2, сантехникийн холбоотой 10 удаагийн дуудлагаар ээлжийн бүрэлдэхүүн гарсан гэмтэлийг түргэн шуурхай засварлан иргэд оршин суугчдыг шинэ жилийн баяраа тав тжхтай тэмдэглэн өнгөрүүлэх гэхцлийг хангаж ажилласан.

ХЯНАСАН:  
ДУЛААНЫ ИНЖЕНЕР

Г.ЧУЛУУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:  
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН:

Г.БААТАРХҮҮ